

Хэрэглэгчдэд зориулсан эм хэрэглэх заавар

Фурамаг 25мг хатуу бүрээс (Furamag 25mg)
Фурамаг 50мг хатуу бүрээс (Furamag 50mg)

Уусдаг Фурагин

Бэлдмэлийг хэрэглэхийн өмнө уг эм хэрэглэх зааврыг анхааралтай уншина уу. Учир нь танд хэрэгтэй чухал мэдээлэл агуулна.

- Уг эм хэрэглэх зааврыг хадгалаарай. Учир нь түүнийг дахин унших шаардлага гарч болно.
- Хэрэв танд ямар нэгэн нэмэлт асуулт гарвал эмч болон эм зүйчээс асуугаарай.
- Уг бэлдмэл танд зориулагдсан учир шинж тэмдэг нь таныхтай адил байсан ч бусдад дамжуулж болохгүй. Учир нь тэдэнд хор хөнөөл учруулж болзошгүй.
- Хэрэв танд ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмч буюу эм зүйчдээ мэдэгдээрэй. Үүнд уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй гаж нөлөө хамаарна. 4-р хэсгийг үз.

Уг эм хэрэглэх зааварт:

1. Фурамаг гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?
2. Фурамаг бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?
3. Фурамаг бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?
4. Илэрч болох гаж нөлөө
5. Фурамаг бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?
6. Савлалтын агууламж болон бусад мэдээлэл

1. Фурамаг гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?

Фурамаг бэлдмэлийн үйлчлэгч бодис уусдаг фурагин нь нитрофураны уламжлалын бактерийн эсрэг бэлдмэл. Түүнийг уусдаг фурагинд мэдрэг бичил биетнээр үүсгэгдсэн шээсний замын халдвар (цистит, уретрит, пиелонефрит), простатит, эмэгтэйчүүдийн халдварын эмчилгээнд хэрэглэнэ.

Бэлдмэлийг бөөрний мэс засал, давсаг дурандах, гуурс тавих үед халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэхээс гадна мөн шээсний замын халдварын дахилтаас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

2. Фурамаг бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?

Дараах тохиолдолд бэлдмэлийг хэрэглэхийг цээрлэнэ.

- Уусдаг фурагин болон нитрофураны уламжлалын бусад бэлдмэл, бэлдмэлийн найрлага дахь бусад туслах бодист (6-р хэсэгт жагсаасан) хэт мэдрэг хүмүүс
- Хүнд явцтай бөөрний эмгэг
- Полинейропати (чихрийн шижингийн)
- Порфири
- Жирэмсэн үе
- Хөхүүл үе

Анхааруулга ба болгоомжлол!

Дараах тохиолдолд бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмч болон эм зүйчдээ мэдэгдээрэй.

- Глюкоз-6-фосфат дегидрогеназын дутагдал (цус задрах эрсдэлтэй)
- Бөөрний үйл ажиллагааны алдагдал. Фурамагийг бөөрний паренхимийн халдварын үед хэрэглэхгүй.
- Цус багадалт
- В бүлгийн витамин ба фолийн хүчлийн дутагдал
- Уушгины өвчин
- Чихрийн шижин (уг бэлдмэл нь полинейропати үүсэх шалтгаан болно)
- Харшилд өртөмтгий бол

Хэрэв танд дээрх заалтаас аль нэг нь байгаа бол эмчлэгч эмчдээ мэдэгдээрэй.

Фурамагийг удаан хугацаагаар хэрэглэснээр:

- Захын мэдрэлийн эмгэг үүсэх шалтгаан болно (тухайн мэдрэлийн хэсгийн мэдрэхүй өөрчлөгдөх, өвдөх). Энэ тохиолдолд бэлдмэлийг хэрэглэхээ зогсоож эмчлэгч эмчдээ мэдэгдэнэ.
- Эмчлэгч эмч элэг бөөрний үйл ажиллагаа болон түүнчлэн ялангуяа 65-с дээш насны өвчтөний уушгины үйл ажиллагааг хянана. Учир нь уушгины хатуурал үүсэх эрсдэлтэй.
- Фурамагийг урьдчилан сэргийлэх тунгаар удаан хугацаагаар хэрэглэж байгаа тохиолдолд бичил биетний эмнэл зүйн ач холбогдол бүхий дасал үүсдэггүй.

Бараг бүх бактерийн эсрэг эмийн эмчилгээний (нитрофураны уламжлалыг оролцуулаад) үед хуурамч мембрант бүдүүн гэдэсний үрэвсэл илэрдэг боловч фурамагийн эмчилгээний үед хуурамч мембрант бүдүүн гэдэсний үрэвсэл илэрсэн талаар мэдээлэгдээгүй.

Бактерийн эсрэг эм хэрэглэх үед гэдэсний хэвийн бичил биетэн дарангуйлагдсаны улмаас суулгалт илэрч байсан өвчтөнд уг гаж нөлөө илэрч болохыг анхаарах хэрэгтэй. Антибиотикоос ялгаатай нь фурамаг нь гэдэсний микрофлорыг бага зэрэг өөрчилдөг. Хөнгөн явцтай хуурамч мембрант бүдүүн гэдэсний үрэвслийн үед бактерийн эсрэг эмийг зогсооно.

Фурамаг хэрэглэж байгаа өвчтөн шээсэнд глюкоз тодорхойлохдоо зэс багасгах аргачлал хэрэглэж байгаа бол уг шинжилгээний үр дүн хуурамчаар эерэг гарч болно. Харин шээсэн дэх глюкозын хэмжээг тодорхойлохдоо ферментийн арга ашиглаж байгаа бол фурамаг нь уг шинжилгээний үр дүнд нөлөөлөхгүй.

Эмийн харилцан үйлчлэл:

Хэрэв та ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, саяхан хэрэглэж дууссан, хэрэглэх гэж байгаа бол энэ тухайгаа эмчлэгч эмч болон эм зүйчид мэдэгдээрэй.

Бэлдмэлийг сульфаниламидын бэлдмэлтэй хамт хэрэглэхгүй. Учир нь цус төлжилтөнд сөрөг нөлөө үзүүлж болно.

Бэлдмэлийг пенициллин, цефалоспорины бүлгийн антибиотиктой хамт хэрэглэвэл бактерийн эсрэг үйлдэл нь бага зэрэг нэмэгдэнэ.

Фурамаг нь тетрациклин болон эритромицинтэй сайн хосолно.

Шээсний орчинг шүлтлэг болгодог эмийн бэлдмэл нитрофураны үйлдлийг сулруулна. Харин шээсний орчинг хүчиллэг болгодог эмийн бэлдмэл нь (аскорбины хүчил, түүнчлэн кальцийн хлорид) фурамагийн үйлдлийг хүчжүүлэх боловч хортой нөлөө илрэх эрсдлийг нь ихэсгэнэ.

Хинолины уламжлалын бэлдмэлтэй (налидиксын хүчил, норфлоксацин, оксолины хүчил) хамт хэрэглэхээс зайлсхийнэ.

Фурамагийг шээсний хүчлийн ялгаралтыг ихэсгэдэг эмтэй (пробенецид, сульфинпиразон) хамт хэрэглэвэл хортой нөлөө нь нэмэгдэж болно.

Фурамагийг хоол хүнс, ундаа, согтууруулах ундаатай хамт хэрэглэх нь:

Хоол нь бэлдмэлийн шимэгдэлтийг сайжруулна. Эмчилгээний явцад согтууруулах ундааны зүйл хэрэглэхээс зайлсхийнэ. Учир нь уусдаг фурагин болон согтууруулах ундааны зүйлийг хамт хэрэглэвэл гаж нөлөө илэрч болно.

Жирэмсэн ба хөхүүл үеийн хэрэглээ:

Жирэмсэн болон хөхүүл үед бэлдмэлийг хэрэглэхийг цээрлэнэ.

Жолоо барих болон машин механизмтай ажиллах чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө:

Фурамаг нь жолоо барих болон машин механизмтай ажиллах чадварт нөлөөлөхгүй.

3. Фурамаг бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?

Бэлдмэлийг эмчлэгч эмчийн зааврыг нарийн баримтлан хэрэглэнэ.

Хэрэв танд ойлгомжгүй зүйл байвал эмчдээ мэдэгдэж шалгаарай.

Бүрээсийг хоолны дараа бүтнээр нь хангалттай хэмжээний шингэнээр даруулж залгиж хэрэглэнэ.

Фурамаг 50мг хатуу бүрээс:

Эмчилгээ: Насанд хүрэгсдэд 50-100мг тунгаар хоногт 3 удаа хэрэглэнэ.

Хүүхэд болон өсвөр насныхны хэрэглээ:

30кг-аас дээш жинтэй хүүхдэд 50мг тунгаар хоногт 3 удаа хэрэглэнэ.

Ээлж эмчилгээ 7-10 өдөр үргэлжилнэ. Шаардлагатай үед ээлж эмчилгээг 10-15 хоногийн дараа давтаж болно.

Урьдчилан сэргийлэх: Насанд хүрэгсэд болон 30кг-аас дээш жинтэй хүүхдэд 50мг тунгаар унтахын өмнө хэрэглэнэ.

Фурамаг 25мг хатуу бүрээс:

Эмчилгээ: Насанд хүрэгсдэд 50-100мг тунгаар хоногт 3 удаа хэрэглэнэ.

Хүүхэд болон өсвөр насныхны хэрэглээ:

30кг-аас дээш жинтэй хүүхдэд 50мг тунгаар хоногт 3 удаа хэрэглэнэ.

1-10 настай хүүхдэд хоногт 5мг/кг тунгаар хэрэглэх ба хоногийн тунг 2-3 хувааж хэрэглэнэ. Хэрэв хоногийн тун нь тэнцүү хэсэгт хуваагдахгүй байвал тунгийн ихэнх хэсгийг унтахын өмнө хэрэглэнэ.

Хүүхэд		Хоногийн тун	
Нас	Биеийн жин	мг	25мг хатуу бүрээсийн тоо
1-1,5 нас	10-13	50-65	2-3
1,5-2 нас	14-15	70-75	3
3-4 нас	16-18	80-90	3-4
5-6 нас	19-24	95-120	4-5
7-10 нас	25-30	125-150	5-6

Ээлж эмчилгээ 7-10 өдөр үргэлжилнэ. Шаардлагатай үед ээлж эмчилгээг 10-15 хоногийн дараа давтаж болно.

Урьдчилан сэргийлэх: Насанд хүрэгсэд болон 30кг-аас дээш жинтэй хүүхдэд 50мг тунгаар унтахын өмнө хэрэглэнэ.

Урьдчилан сэргийлэх:

1-10 настай хүүхдэд хоногт 1-2мг/кг тунгаар унтахын өмнө давсагны архаг үрэвслийн үед 3-6 сар, эсвэл пиелонефритийн үед бөглөрлөөс сэргийллтэл хэрэглэнэ.

Тусгай бүлэг өвчтөн:

Фурамагийг элэгний үйл ажиллагааны өөрчлөлттэй өвчтөнд болгоомжтой хэрэглэх ба эмчилгээний явцад элэгний үйл ажиллагааг хянахыг зөвлөнө.

Фурамагийг бөөрний үйл ажиллагааны өөрчлөлттэй өвчтөнд болгоомжтой хэрэглэх ба эмчилгээний явцад бөөрний үйл ажиллагааг хянахыг зөвлөнө.

Фурамагийг настангуудад болгоомжтой хэрэглэнэ.

Тун хэтэрсний улмаас илрэх нөлөө:

Тун хэтэрсэн тохиолдолд яаралтай эмчид мэдэгдэнэ. Гаж нөлөө гэсэн хэсэгт дурьдсан шинж тэмдгийг анхаарна.

Хэрэв та фурамагийг хэрэглэлгүй мартаж өнгөрөөсөн бол.

Хэрэв та бэлдмэлийн тунг хэрэглэлгүй мартаж өнгөрөөсөн бол дараагийн тунг ердийн хугацаанд нь хэрэглэнэ. Мартаж өнгөрөөсөн тунг нөхөхийн тулд тунг давхарлаж хэрэглэхгүй.

Хэрэв та фурамагийн эмчилгээг зогсоох бол.

Эмчийн зөвшөөрөлгүйгээр эмчилгээг зогсоож болохгүй. Хэрэв та эмчлэгч эмчийн бичсэн ээлж эмчилгээг дуусгалгүйгээр зогсоовол эмчилгээний үр нөлөө хүссэн хэмжээнд хүрэхгүй.

Хэрэв танд бэлдмэлийг хэрэглэхтэй холбоотой ямар нэгэн нэмэлт асуулт гарвал эмчлэгч эмчээсээ асуугаарай.

4. Илэрч болох гаж нөлөө

Бэлдмэлийг хэрэглэх үед бусад эмийн бэлдмэлийн нэгэн адилаар гаж нөлөө ажиглагдаж болно.

Гаж нөлөөний давтамжийг дараах байдлаар ангилсан.

Байнга илрэх: 10 өвчтөнд 1-с олон тохиолдох.

Олонтаа илрэх: 100 өвчтөнд 1-с олон, 10 өвчтөнд 1-с цөөн тохиолдох.

Хааяа илрэх: 1000 өвчтөнд 1-с олон, 100 өвчтөнд 1-с цөөн тохиолдох.

Ховор илрэх: 10000 өвчтөнд 1-с олон, 1000 өвчтөнд 1-с цөөн тохиолдох.

Маш ховор илрэх: 10000 өвчтөнд 1-с цөөн тохиолдох.

Олонтаа илрэх:

- Толгой өвдөх

Хааяа илрэх:

- Толгой эргэх, нойрмоглох
- Дотор муухайрах, гэдэс дүүрэх (бэлдмэлийг хоолтой хамт хэрэглэснээр уг гаж нөлөө багасна)

Ховор илрэх:

- Захын мэдрэлийн эмгэг
- Харааны өөрчлөлт
- Бөөлжих, хоолонд дургүй болох, суулгах, өтгөн хатах, хэвлийн өвдөлт (бэлдмэлийг хоолтой хамт хэрэглэснээр уг гаж нөлөө багасна)
- Гөвдрүүт тууралт, загатнаа

Маш ховор илрэх:

- Цус төлжилтийн эмгэг (агранулоцитоз, тромбоцитопени, цус төлжилгүйдлийн цус багадалт).
- Цочмог болон архаг явцтай уушгины урвал. Уушгины цочмог урвал түргэн илэрдэг. Энэ нь хүнд явцтай амьсгаадах, халуурах, цээжээр өвдөх, цэртэй болон цэргүй ханиалгах, эозинофилийн тоо олшрох зэрэг шинжээр илэрнэ. Уушгины цочмог урвалтай хамт чонон хөрвөс, загатнаа, тууралт, судасны хаван, булчингийн өвдөлт зэрэг шинж ажиглагдсан талаар тэмдэглэгдсэн. Уушгины цочмог урвал харшлын урвал дээр суурилж хэдэн цагийн дотор, ховор тохиолдолд хэдэн минутын дотор үүсдэг. Уушгины цочмог урвал эргэж хэвийн болох ба эмчилгээг зогсоосны дараа арилдаг. Архаг явцтай уушгины урвал нитрофураныг удаан хугацаагаар хэрэглэж байгаад зогсоосны дараа илэрч болно. Энэ нь амьсгаадах шинж аажим дордох, амьсгал түргэсэх, тогтворгүй халууралт, эозинофилийн тоо олшрох, даамжрах явцтай ханиалга, уушгины завсрын эдийн үрэвсэл, уушгины хатуурал зэрэг шинжээр илэрнэ.
- Нойр булчирхайн үрэвсэл (бэлдмэлийг хоолтой хамт хэрэглэснээр уг гаж нөлөө багасна)
- Судас мэдрэлийн хаван, чонон хөрвөс, эксфолиатив дерматит, олон хэлбэрийн улайлт, эргэх явцтай үс унах.
- Үений өвдөлт
- Гавлын дотоод даралт бага зэрэг ихсэх
- Биеийн хэм ихсэх, ядрах
- Цөс зогсонгишлын шарлалт, элэгний үрэвсэл.

Эдгээр гаж нөлөөг багасгахын тулд бэлдмэлийг хангалттай хэмжээний шингэнээр даруулж уух ба В бүлгийн витамин, гистамины эсрэг эм хэрэглэнэ.

Фурамагийг хэрэглэх үед шээсний өнгө шар буюу хүрэн болж болно.

Хэрэв ямар нэгэн гаж нөлөө хүнд явцтай болох, эсвэл уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй гаж нөлөө илэрвэл эмчлэгч эмчдээ мэдэгдээрэй.

5. Фурамаг бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?

25°C-аас доош хэмд хадгална. Гэрэл болон чийгнээс хамгаалахын тулд үйлдвэрийн савлагаанд нь хадгална.

Хүүхэд үзэж хүрэхээргүй газар хадгална.

Савлалтан дээрх хүчинтэй хугацаа дууссанаас хойш бэлдмэлийг хэрэглэхгүй. Хүчинтэй хугацаа нь тухайн сарын сүүлийн өдөр дуусна.

Ямар нэгэн эмийн бэлдмэлийг бохирын ус болон гэрийн хог хаягдалд хаяж болохгүй. Цаашид хэрэглэхгүй бэлдмэлийг хэрхэн устгах талаар эм зүйчээс асуугаарай. Энэ нь хүрээлэн буй орчныг хамгаалахад тустай.

6. Савлалт ба бусад мэдээлэл

Найрлага:

Үйлчлэгч бодис: уусдаг фурагин

Фурамаг 25мг хатуу бүрээст 25мг уусдаг фурагин агуулагдана.

Фурамаг 50мг хатуу бүрээст 50мг уусдаг фурагин агуулагдана.

Туслах бодис: калийн карбонат, магнийн карбонат, тальк.

Савлалтын агууламж ба дүрслэл:

Фурамаг 25мг хатуу бүрээс

Улбар шар-хүрнээс улаан-хүрэн нунтаг агуулсан бор шар өнгийн хатуу царцмаган бүрээс.

Цагаан, шар, улбар шар буюу улбар шар-хүрэн хэсгүүд зөвшөөрөгдсөн.

Бүрээсийн агууламж: царцмаг, будагч бодис – титанийн хоёрч исэл E171, төмрийн шар исэл E172.

Фурамаг 50мг хатуу бүрээс

Улбар шар-хүрнээс улаан-хүрэн нунтаг агуулсан шар өнгийн хатуу царцмаган бүрээс.

Цагаан, шар, улбар шар буюу улбар шар-хүрэн хэсгүүд зөвшөөрөгдсөн.

Бүрээсийн агууламж: царцмаг, өнгө оруулагч – титанийн хоёрч исэл E171, хиолин шар E172

Савлалт: 10 хатуу бүрээсийг блистертэй гаргах ба 3 блистерийг (30 хатуу бүрээс) эм хэрэглэх зааврын хамт цаасан хайрцганд савлан гаргана.